



“ЭЛЭГНИЙ ТӨВ”, ОНОМ САНД

**ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМ
ХАЛДВАРТ ӨВЧИН СУДЛАЛЫН
ҮНДЭСНИЙ ТӨВ**

13335 Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг,
Нам Ян Жугийн гудамж 32/1, Утас: 45 39 94,
Факс: (976-11) 45 86 99, E-mail: info@nccd.gov.mn,
<http://www.nccd.gov.mn>

2021. 12. 07 № 9/3827.

танай _____ -ны № _____ -т

Мэдэгдэл хүргүүлэх тухай

Судлаач Д.Наранжаргал нарын тус төвийн Эрдмийн зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлж, дүгнэлт гаргуулахаар ирүүлсэн “Ковид-19-ын дархлаажуулалтын дархлааны хариу урвал болон үр нөлөөний олон улсын судалгаа”-ны арга, аргачлалыг хүлээн авч, Халдварт өвчин судлалын үндэсний төвийн “Эрдмийн зөвлөлийн үйл ажиллагааны дүрэм”-ийн 5.3-д заасны дагуу шинжээчдийн багийг томилон ажиллуулсан.

Шинжээчдийн багаас ирүүлсэн “тухайн судалгааны арга аргачлалыг засч сайжруулах шаардлагатай байна” гэсэн дүгнэлтийг тус төвийн Эрдмийн зөвлөлийн гишүүд хүлээн зөвшөөрч, Эрдмийн зөвлөлийн 2021 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн хуралд оролцсон гишүүдийн олонхийн саналаар шинжээчдийн багийн дүгнэлтэд дурдсан асуудлуудыг засссаны дараа уг судалгааны ажлыг дахин хэлэлцэх нь зүйтэй гэсэн шийдвэр гаргасан.

Энэ нь Халдварт өвчин судлалын үндэсний төвийн Эрдмийн зөвлөлийн үйл ажиллагааны дүрмийн Эрдмийн зөвлөлийн хурал, түүний дэг, шийдвэр гаргах гэсэн тав дахь хэсгийн 5.4, 5.8-д заасан Эрдмийн зөвлөлийн бүх гишүүдийн 75-aас доошгүй хувийн ирцтэй хурлаар хэлэлцэж, хуралд оролцсон гишүүдийн олонхийн саналаар гаргасан албан ёсны шийдвэр юм.

Тус төвийн Эрдмийн зөвлөлөөс томилогдсон Шинжээчдийн багийн дүгнэлт болон Эрдмийн зөвлөлийн шийдвэр нь эрхэм эрдэмтэн, судлаач Та бүхэнд судалгааны ажлаа Монгол улсын холбогдох хууль тогтоомж, баримт бичгийн стандарт, судалгааны ажилд тавигдах шаардлагын дагуу засч ирүүлэхийг хүсч байгаа хэрэг бөгөөд Шинжээчдийн багийн дүгнэлтийн дагуу судалгааны ажлаа засч сайжруулан ирүүлсэн тохиолдолд Эрдмийн зөвлөл дүрмийнхээ дагуу шуурхай хэлэлцэн шийдвэрлэнэ.

Тус төвийн Эрдмийн зөвлөлийн дээрх шийдвэр нь холбогдох хууль тогтоомж, дүрэм, журамд нийцсэн бөгөөд харин Та бүхний хийсэн судалгааны ажлыг гацаах, удаашруулах, ач холбогдлыг нь бууруулах санаа, зорилго огт агуулаагүй тул үүнийг ойлгон, хүлээн авч, асуудлыг хүндрүүлэхгүй байхыг хүсч байна.

Тус төвийн Эрдмийн зөвлөлийн хурлын шийдвэрийг мэдэгдсэнээс хойш эрхэм эрдэмтэн, судлаач Та бүхэн төвийн удирдлага, Эрдмийн зөвлөлийн гишүүд, Шинжээчдийн багийн ахлагч, гишүүдийг доромжилж, заналхийлэн утсаар ярих, мессеж бичих, олон нийтийн сүлжээгээр доромжилсон, гутаасан өнгө аястай худал мэдээллийг удаа дараа мэдээлэх зэргээр Эрүүгийн хуулийн Худал мэдээлэл тараах гэсэн 13.14 дүгээр зүйл, Заналхийлэх гэсэн 13.5 дугаар зүйлд заасан гэмт хэргийн шинжтэй хууль бус үйлдлийг хийж үүнийгээ зогсоохгүй байгаа тул тус төвийн зүгээс Эрдмийн зөвлөлийн гишүүд болон ажилтнуудынхаа эрх ашгийг хамгаалах үүргийнхээ дагуу Та бүхнийг хууль бус үйлдлээ даруй зогсоохыг шаардаж энэхүү мэдэгдлийг хүргүүлж байна.

Хэрэв энэхүү мэдэгдлийг хүргүүлснээс хойш хууль бус үйлдлээ зогсоохгүй бол тус төв нь Эрдмийн зөвлөлийн гишүүдийнхээ хууль ёсны эрхийг хамгаалуулахаар холбогдох хуулийн байгууллагад хандах болно гэдгээ үүгээр мэдэгдэж байна.

ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ

ЭРДМИЙН ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



U. DASHDORJ

Ц.БИЛЭГТСАЙХАН